



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.04.24 № А-1/1660
танай _____-ны № _____-т

**Тодруулгын хариу хүргүүлэх
тухай**

Тус газраас зарласан БШУЯ/20240101137 дугаартай XIII.3.1.2 “Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны барилга, 150 ор /Баянхонгор, Баянхонгор сум” төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариу хүргүүлж байна. Үүнд:

Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
Тус төсөл, арга хэмжээний магадлалаар баталгаажсан төсөвт өртөг 6,984,652,600.0 төгрөг байхад 4,569,500,000.0 төгрөг буюу 2,415,152,600.0 төгрөгөөр бууруулан зарласан байна. Тендерийн баримт бичгийг барилгын ажилд мөрдөгдөж буй норм дүрэм, стандартын дагуу барилгын төсвийн программ ашиглан бэлтгэх ба тендерийн баримт бичигт тусгагдсан нийт ажлыг бууруулсан төсөв буюу 4,569,500,000.0 төгрөгөөр гүйцэтгэх ямар ч боломжгүй байна. Иймд магадлалаар баталгаажсан төсвийг бууруулан зарласан учир шалтгааныг захиалагч байгууллага болох БШУЯ-аас тодруулж өгнө үү.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтад захиалагч нь “худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах” үүрэгтэй гэж заасан тул зураг төслийн магадлалын дүгнэлтэд заасан дүнгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломжгүй болно.

ДАРГА



Ц.БАТЗУЛ

020020105 СБТ-11261 6529903

1324024274